



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг
шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолоор баталсан “Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг шагнаж урамшуулах журам”-ын шалгуур үзүүлэлтийг хангаж Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш, сурагчдыг шагнаж урамшуулсугай.

2. Шаардлагатай төсвийг хавсралтаар баталж, зарцуулагдах 3,440,000 (гурван сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД